

Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр, байршил: Нэхий таннери ХХК
 Огноо: 2024.12.19

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо								Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар	
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7	Гишүүн 8			
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	40	37	35	35	35	35	35	35	36	40	36	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	10	7	7	8	8	7	8	10		8.125	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	30	30	28	28	28	28	28	28	28	28	28.25	
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
	Нийт оноо	100	97	90	90	91	91	95	92	98	93		

Ажлын хэсгийн дарга:
Дархан-Уул аймгийн БОГ-ын дарга



(Г.Батбаяр)

Нарийн бичгийн дарга:
БОГ-ын газрын хэвлий, тусгай хамгаалалттай
Газар нутаг, БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн

А. Энхжин (А.Энхжин)

Хараа ерөө сав газрын захиргааны газрын ахлах мэргэжилтэн

Г. Оюунгэрэл (Г.Оюунгэрэл)

БОГ-ын Усны нөөц ашиглалт, хамгаалалт, төрийн бус байгууллага,
судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

Я. Батбилэг (Я.Батбилэг)

БОГ-ын Орчны бөхирдол, хог хаягдал, химийн хорт бодис,
байгалийн гамшиг хариуцсан мэргэжилтэн

А. Аззаяа (А.Аззаяа)

ГХБХБГ-ын Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Ч. Оюундарь (Ч.Оюундарь)

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн БОШЛ-ийн хяналтын
шинжээч чанрын менежер

Э. Сайнзаяа (Э.Сайнзаяа)

Экологийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн ахмад

Э. Баточир (Э.Баточир)

Хүлээн зөвшөөрсөн:

Урсгалын үйлчилгээний үйлчилгээний захирал
Орчлонгийн үйлчилгээний захирал



(Б.Гармаа)

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ҮЙЛДВЭРИЙН
БҮСЭД БАЙРЛАХ “НЭХИЙ ТАННЕРИ” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ
БУЙ “ДАРХАН АРС ШИР БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

Агуулга

1	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
	Төслийн нэр:.....	4
	Төсөл хэрэгжүүлэгч:	4
	Төслийн талбайн байршил, хэрэгжиж буй орчны тойм зураг.....	4
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	4
1.3	Үйл ажиллагаа	5
1.4	Дэд бүтэц.....	5
1.5	Хог хаягдлын менежмент	5
1.5.1	Хатуу хог хаягдал.....	6
1.5.2	Химийн бодисын хог хаягдал	6
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	7
2.1.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	7
2.1.2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	22
2.1.3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	23
2.1.4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	23
2.1.5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	41
2.1.6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	47
2.1.7	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	50

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 2-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7
Хүснэгт 2-2. Хэмжилтийн үр дүн	10
Хүснэгт 2-3. Хүний эрүүл мэндэд хүхэрт үстөрөгчийн төрөл бүрийн агууламжийн үзүүлэх нөлөө - амьсгалын замаар дамжин өртөх.....	11
Хүснэгт 2-4. Усны тоолуурын бүртгэл	14
Хүснэгт 2-5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	22
Хүснэгт 2-6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 2-7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	41
Хүснэгт 2-8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	47
Хүснэгт 2-9. Тоосонцрын хэмжилтийн үр дүн	48
Хүснэгт 2-10. Агаар бохирдуулагч бодисын хэмжилтүүд	49
Хүснэгт 2-11. Хаягдал бохир усны шинжилгээний хариу.....	49
Хүснэгт 2-12 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	50
Хүснэгт 2-13. Нэхий таннери ХХК-ийн үйлдвэрийн хог хаягдлын кодчилсон хүснэгт.....	53
Хүснэгт 2-14. Хог хаягдал шилжүүлэх байгууллагууд.....	54

Зургийн хүснэгт

Зураг 1-1. Үйлдвэрийн талбайн байршил.....	4
Зураг 2-1.Түүхий эд буух явц	7
Зураг 2-2. Хий хэмжигч багажууд / Dräger Pac® 8500 болон Dräger X-am 2500/.....	9
Зураг 2-3. Хэмжилтийн багаж / дуу шуугиан, гэрэл, салхины хурд, температур, чийг/.....	10
Зураг 2-4. Хэмжилтийн явц.....	12
Зураг 2-5. Харуул хамгаалалтын ажилчны зааварчилсан	12
Зураг 2-6. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төлөвлөгөө	13
Зураг 2-7. Санамж тэмдэглэгээнүүд.....	14
Зураг 2-8. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ №029662.....	15
Зураг 2-9. Механик цэвэрлэгээний түлк, голыг шинэчилсэн.....	16
Зураг 2-10. Нойтон, дэвтээлгэний барабан	17
Зураг 2-11. Бороожуулалт суурилуулсан байдал.....	18
Зураг 2-12. Химийн бодисын агуулахын тэмдэгжүүлэлт	19
Зураг 2-13. Тэмдэгжүүлэлт	20
Зураг 2-14. Мал эмнэлэгийн халдваргүйтэл хийсэн акт	21
Зураг 2-15. Ногоон байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ	22
Зураг 2-16. Тоноглолын газардуулгын эсэргүүцэл хэмжсэн протокол	25
Зураг 2-17. Галын хорны үзлэгийн хүүдас	26
Зураг 2-18. Журам, норм баталсан тушаал.....	30
Зураг 2-19. Хувийн хамгаалах хэрэгсэл олгосон бүртгэл	30
Зураг 2-20.Сургалтын гэрээ	33
Зураг 2-21. Асгаралтын үед ашиглах боломжтой шингээгч материал	34
Зураг 2-22. Химийн хорт ба аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сертификат	37
Зураг 2-23. 2024 оны химийн бодисын агуулахад байгаа бодисууд, сав баглаа боодлын тооллогын бүртгэл.....	40
Зураг 2-24. Үйлдвэрийн ариутгалын явц	41
Зураг 2-25. Ариутгалын бодисын танилцуулга.....	42
Зураг 2-26.Энгийн хог хаягдлын тээвэрлэлтийн бүртгэл	42
Зураг 2-27. Энгийн хог хаягдлын гэрээ	43
Зураг 2-28. Гадна талбайн цэвэрлэгээний явц.....	44
Зураг 2-29. Дархан-Ус суваг ХК-д шилжүүлсэн төлбөрийн баримт.....	45
Зураг 2-30. Түүхий эд материал буулгах явц	45
Зураг 2-31. Цэцүүх трейд ХХК-д шилжүүлсэн аюултай хог хаягдлын бүртгэл	46
Зураг 2-32. Агаараас сорьц авсан багаж.....	48
Зураг 2-33. Мониторингийн хэмжилт, дээжлэлтийн явц	48
Зураг 2-34. Эрчим хүчний хэсэгчилсэн аудитын тайлангийн нүүр.....	52
Зураг 2-35. Хог хаягдлыг гэрээнүүд.....	54
Зураг 2-36. Мэдээлэл шинэчилж байгаа байдал	55
Зураг 2-37. Мод тарьж буй явцын зураг	58
Зураг 2-38. “Дархан-Ус суваг” ХК-тай хийсэн гэрээ “Хэрэгцээний цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах ус ашиглалтын гэрээ”	59
Зураг 2-39. Уурын гэрээний нэмэлт өөрчлөлт.....	60
Зураг 2-40. Үйлдвэрийн шинэчилсэн ХАБЭА-ны сургалтын өрөө	61
Зураг 2-41. ХАБЭА-ны сургалтын явц	62
Зураг 2-42. Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг, багц шинжилгээний гэрээ	63

Зураг 2-43. Ажилчдын үзлэгийн хуваарь, танилцсан байдал.....	64
Зураг 2-44. Анхны тусламжийн хайрцаг	64

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Төслийн нэр: “Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр”
Төсөл хэрэгжүүлэгч: “Нэхий таннери” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 1911024140
- Регистрийн дугаар: 4280288
- Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг
- Утас: +976 70378499

Төслийн талбайн байршил, хэрэгжиж буй орчны тойм зураг

Үйлдвэрийн байр нь Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р баг, үйлдвэрийн бүсэд байрлах ба 8.9 га талбайтай, 21737 м² бүхий цутгамал бетон карказан барилгад үйл ажиллагаа явуулдаг.

Төслийн талбайн байршлын зургийг Зураг 1-1-т харууллаа.



Зураг 1-1. Үйлдвэрийн талбайн байршил

1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэхий таннери ХХК нь Дархан Нэхий ХК-ийн охин компани бөгөөд арьс шир боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь түүхий эдээс эхлэн нойтон болон хуурай боловсруулалт хийж, хагас боловсруулсан арьс үйлдвэрлэн оёдлын охин компаниуд болон дотооддоо борлуулалт хийдэг. 2013 оноос механикийн боловсруулалт хийж бэлэн боловсруулсан арьс үйлдвэрлэн ажиллаж байна.

Нэхий боловсруулах үйлдвэр нь 2018 оны 11-р сараас Нэхий таннери ХХК болж бүтцийн өөрчлөлт хийж Евро стандартад нийцсэн байгальд ээлтэй, эко технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд экологийн шаардлага хангасан дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн болох

хонины нэхий, ямааны арьс, үхэр сарлагийн шир, ноос зэргийг боловсруулж зах зээлд худалдаалж байна.

2020 оноос Бид нийт хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг тогтмол өндөр байлгах зорилгоор чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 олон улсын стандартыг үйлдвэртээ нэвтрүүлсэн нь хэрэглэгч харилцагчдынхаа итгэлийг улам баталгаажуулж байгаагийн нэг илрэл болсон.

1.3 ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйлдвэр нь өдөрт 1500 ширхэг хонины арьс, 500 ширхэг үхрийн шир боловсруулах хүчин чадалтай.

Нэхий таннери ХХК нь

- Нэхий боловсруулах үйлдвэр
- Шир савхины үйлдвэр гэсэн 2 үндсэн чиглэлээр үйлдвэрлэл явуулж байна.

Нэхий боловсруулах үйлдвэр нь түүхий эдийн 105-р тасаг, нойтон боловсруулах 110-р тасаг, гүйцээн боловсруулах 160, 180-р тасгаас бүрдэнэ.

Шир, савхи боловсруулах үйлдвэр нь түүхий эдийн 106-р тасаг, нойтон боловсруулах 111-р тасаг, гүйцээн боловсруулах 161, 181-р тасагтай. Мөн удирдлагын баг буюу ИТА, засвар үйлчилгээний баг буюу ТНА гэсэн бүтэцтэй нийт 100 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Нийт ажилтнуудын 18-24 насны ажилтан 10.8%, 25-30 нас 22.9%, 31-36 нас 33.7%, 37-43 нас 9.6%, 44-50 нас 13.3%, 51-55 нас 4.8%, 56-аас дээш насны ажилтан 4.8%-г тус тус эзэлж байна.

1.4 ДЭД БҮТЭЦ

Дулаан, эрчим хүчний хангамж

Үйлдвэрийн байгууламжийн дулаан, эрчим хүчний хангамжийг Дархан-Уул аймгийн Дархан сумын төвлөрсөн хангамжаас “Дархан дулааны сүлжээ” ТӨХК –тай гэрээ байгуулж ханган ажилладаг. Эрчим хүчний хувьд газраар дамжуулан 6 вольт хүчдэлтэй 2 талын тэжээлттэй шугамаар цахилгаан эрчим хүч авахаас гадна өөрийн дэд станцтай юм.

Усан хангамж

Нэхий таннери ХХК нь “Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх аж ахуйн гэрээ”-г “Дархан-Ус суваг” ХК-тай байгуулан ус хангамжийг шийдэж ажилладаг.

1.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын тухай хууль нь 2012 оны 5-р сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд 2017 он шинэчлэн баталсан. Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах, экспортлох болон хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахыг заасан. Мөн энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхт хог хаягдлаас бусад хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна. Хог хаягдлын тухай хуульд аж ахуйн нэгж байгууллага нь:

- I. Хог хаягдлыг дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх;
- II. Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;
- III. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах;
- IV. Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон тусгай цэгт устгах ёстой талаар заажээ.

1.5.1 Хатуу хог хаягдал

Ажилчдын ахуйн хэрэглээ болон үйлдвэрээс гарсан хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн савуудад хадгалан хог хаягдлын гэрээний дагуу нэгдсэн цэгт зайлуулдаг.

1.5.2 Химийн бодисын хог хаягдал

Хог хаягдлын тухай хуульд “аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал гэж заасан байна.

Үйл ажиллагаанаас гарах химийн бодисын хог хаягдал /өнгөт металл тоног төхөөрөмжийн өнгөлөгч будгийн сав, баглаа боодол болон даралтат хоосон сав, г.м /-ыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалан, устгах, дахин ашиглах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.

2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.1.1.1 Агаарын чанарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
	1	2	3
1	Түүхий эд, бүтээгдэхүүнийг муудсан үнэр орчинд тархах	Түүхий эд хүлээн авах ажилчид маск зүүх, муудсан үйлдвэрийн шаардлага хангахгүй түүхий эдийг чанар шалгагч шалгаж ялган зориулалтын талбайд ангилан буцаана.	Түүхий эд буулгах талбай
2		Үйлдвэрийн барилгад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх	Үйлдвэрийн дотор орчин
3	Үйлдвэрийн дотоод агаарын чанар муудах, хэм нэмэгдэх	Үйлдвэрийн байранд дотоод орчныг сайжруулах, ажлын байрны үзлэг хийх, агааржуулалтыг тогтмол шалгах	Замууд
4	Зам дээрх тээврийн хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх	Түүхий эд материал тээвэрлэх ирэх тээврийн хэрэгслийг үйлдвэрийн талбайд тогтсон маршрутаар зорчуулах	Үйлдвэрийн талбай

Үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, материалыг зориулалтын бэлтгэсэн талбайд буулгаж, материалын үлдэгдэл зэргийг тогтмол цэвэрлэгээг хийж ажилласан.

Үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 10-р сараас 3-р саруудад эрчимжиж эхэлдэг учраас түүхий эд татан авах цуглуулах үйл ажиллагаа 8-р сарын 5-наас эхэлдэг. Түүхий эдийг баруун аймгуудаас цуглуулан үйлдвэрийн талбайд буулгадаг. 2024 оны 11-р сарын байдлаар нийт 124,361 ширхэг түүхий эдийн татан авалт хийсэн байна. Үйлдвэрийн талбайд авчирсан түүхий эдийг тээврийн хэрэгслээс буулгах явцад чанарын ангилан ялгалт хийгдэнэ. Түүхий эдийн буулгалт, ангилан ялгалт болон дараах талбай цэвэрлэгээний явцыг доорх зурагт харууллаа.



Зураг 2-1.Түүхий эд буух явц

Үйлдвэрийн барилгад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг гүйцэтгэхээр Үндэсний итгэмжлэлийн төвийн ISO/IEC 17020 итгэмжлэлтэйгээр ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх Хэлт энд Сэфти Солушинс ХХК-ийг сонгон ажлыг гүйцэтгэж байна.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг дараах байдлаар гаргаад байна.

2024 онд үйлдвэрийн байгууламжид Дархан-Уул аймгийн мал эмнэлгийн газраар ариутгаж цэвэрлэсэн. Үүссэн энгийн хог хаягдлыг Дархан хотын тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулж тээвэрлэх, устгах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүссэн хог хаягдлыг тогтмол зайлуулах, хог хаягдал байршуулах талбайг цэвэрлэх, аюултай хог хаягдлыг тусгай эрх байгууллагад шилжүүлэх ажлыг үр дүнг хог хаягдлын менежментийн хэсэгт дэлгэрэнгүй тусгав.

Үйлдвэрийн байранд дотоод орчныг сайжруулах, ажлын байрны үзлэг хийх, агааржуулалтыг тогтмол шалгах ажлыг ХАБ болон Үйлдвэрийн технологич нар хамтран зохион байгуулдаг.

Манай байгууллага нь үйлдвэрийн дотоод агаарын чанарыг хянах, ажилчдын ажлын байрыг нөхцөлийг хангах зорилгоор Drägerwerk AG & Co.KGaA компанийн хий хэмжигч Dräger Pac® 6000 болон Dräger X-am 2500 маркийн 2 төрлийн багажаар хэмжилт хийж дотоод агаарын чанарт хяналт хийж ажиллаж байна (Зураг 2-2).

Dräger Pac® 6000- нэг хий хэмжигч

- Хувийн орчны агаарын мониторинг
- H₂S мэдрэгч нь 0.4-100 ppm хүртэл концентрацыг хэмждэг

Dräger X-am 2500 - Олон үйлдэлт хий хэмжигч

- 1-ээс 4 хүртэлх хий мэдрэгчтэй
- Хувийн орчны агаарын мониторинг
- O₂, CO, NO₂, SO₂ болон H₂S, шатамхай хий, уур мэдрэгчтэй

Урт хугацааны цахилгаан химийн мэдрэгч буюу устөрөгчийн сульфидын мэдрэгчийн тусламжтайгаар өндөр нарийвчлалтайгаар орчны маш бага хийг ялгарлыг хэмжинэ.

Цахилгаан химийн зарчмаар ажилладаг H₂S мониторууд нь мэдрэгч рүү хүхэрт устөрөгчийн хий тархах үндсэн дээр ажилладаг бөгөөд H₂S концентрацитай пропорциональ цахилгаан дохио үүсгэдэг. Тиймээс энэ нь H₂S-ийн бага концентрацыг ч үнэн зөв хэмжих боломжийг олгодог бөгөөд энэ нь орчны агаар дахь H₂S мониторинг хийхэд зайлшгүй шаардлагатай.

Мөн үйлдвэрийн одоо орчны дуу шуугиан, гэрэл, салхины хурд, температур, чийг хэмжигч багаж хэмжилт хийж ажиллаж байна (Зураг 2-3).



Зураг 2-2. Хий хэмжигч багажүүд / Dräger Pac® 8500 болон Dräger X-am 2500/




Зураг 2-3. Хэмжилтийн багаж / дуу шуугиан, гэрэл, салхины хурд, температур, чийг/ Үйлдвэрийн дотоод орчинд хийн хэмжилтийг үйлдвэрийн үйл ажиллагаа бүрэн болон хагас ачааллын үеийн хэмжилтүүдийг хийж хяналт тавьж ажиллаа. Хэмжилт хийсэн хугацаа болон хэмжилтийн үр дүнг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2-2. Хэмжилтийн үр дүн

№	Хэмжилт хийсэн байршил	CH ₄ , %	O ₃ , %	CO, ppm	H ₂ O, ppm
8-р сар					
1	110-р тасаг /нойтон боловсруулалтын цех/	0	20.9	2	0.0
2	Химийн агуулах	0	20.0	2	0.0
11-р сар					
1	110-р тасаг /нойтон боловсруулалтын цех/	0	20.9	2	0.0
2	Химийн агуулах	0	20.9	0	0.0

Effects Of H₂S Exposure



Хүснэгт 2-3. Хүний эрүүл мэндэд хүхэрт үстөрөгчийн төрөл бүрийн агууламжийн үзүүлэх нөлөө - амьсгалын замаар дамжин өртөх

Өртөх (ppm)	Хугацаа	Хамгаалах хувцас, хэрэгсэлгүй хүн
0.03	Хязгааргүй	Нөлөөгүй
0.03-2		Үнэрийн босго (хязгаар)
10	8 цаг хүртэл	Нөлөөгүй
10-20		Нүдэнд үзүүлэх нөлөөллийн босго (хязгаар)
20-200		Толгой өвдөх, дотор муухай оргих, бие тамир тэнхээгүй болох, хөл хөндүүрлэх
200-500	1 минут	Хамар, хоолой хорсох, загатнах, толгой эргэх, нүд бүрэлзэх, түргэн зуур ухаан алдах
500-900	1 минут	Комд орох, шөрмөс татах- таталт өгөх, сэргэсний дараа ухаан балартах
900 ба түүнээс дээш	1 минут	Гэнэт комд орох, үхэх

ppm = агаар дахь нэг саяд ноогдох хэсэг

15 ppm агууламж бол богино хугацааны нөлөөллийн олон улсын зөвшөөрөгдөх хэмжээ бөгөөд ажлын байрны орчинд зөвшөөрөгдөх дээд хэмжээг заадаг. Гэхдээ Америкийн Нэгдсэн Улсын төрийн аж үйлдвэрийн эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн хурлаар агаарт агуулагдах хүхэрт үстөрөгчийн (H₂S) хэмжээний зөвшөөрөгдөх босго (TLVs) утгыг шинэчлэн тогтоосон.

2010 онд тус хурлаар H₂S хийн дундаж хугацааны зөвшөөрөгдөх хэмжээг 1 ppm, богино хугацааны нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээг 5 ppm болгож өөрчилжээ. АНУ-д тус хурлаас зөвлөмж болгож гаргасан зөвшөөрөгдөх хэмжээг заавал мөрдлөг болгодоггүй ч эдгээр зөвлөмжийг хүний эрүүл мэндэд хүхэрт үстөрөгчийн үзүүлж буй нөлөөллийн талаар олон жил цуглуулсан шинжлэх ухааны судалгааны тоо баримт, мэдээ дээр үндэслэн боловсруулдаг. Мөн уг зөвлөмж нь “эрүүл мэндийн ямар нэг ноцтой сөрөг нөлөө үзүүлээгүй ч амьдралынхаа ажилласан бүхий л хугацаанд өдөр бүр давтамжтайгаар өртөж буй бүх ажилчдын” өртөлтийн байдлыг төлөөлж чадахуйц юм.


8-р сар



11-р сар



Химийн бодисын агуулах



110-р тасаг

Зураг 2-4. Хэмжилтийн явц

Түүхий эд материал тээвэрлэх ирэх тээврийн хэрэгслийг үйлдвэрийн талбайд зорчуулахад харуул хамгаалалт болон ХАБ-ын ажилтнаас зааварчилгаа авч тогтсон маршрутаар зориулалтын талбайд буулгах ажлыг хийж гүйцэтгэдэг.




Зураг 2-5. Харуул хамгаалалтын ажилчны зааварчилсан

2024 онд Энержи Баланс ХХК-иар үйлдвэрт эрчим хүчний аудит хийлгэсэнтэй холбоотойгоор 2024-2026 оны хугацаанд эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төлөвлөгөөг дотооддоо боловсруулж баталсан. Үүний хүрээнд үндсэн 3 хэсгийн хийгдэх ажлуудыг гүйцэтгэснээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.и


БАТЛАВ

Нэхий таннери ХХК-ийн Гүйцэтгэх Захирал



тамга /Б.Бямбаатог/

Энгийн Баянц ХХК-ийн Захирал



тамга /Д.Баасансүрэн/

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Эрчим хүчний хэмжээ арга хэмжээнүүд	Хоронго оруулалт, сая тогтрог	Жилийн хэмнэлт			ХО нэмэх хугацаа, сар	Бууруулах CO2, тонн	Хэрэгжүүлэх хугацаа												Хариуцах этгн		
			ЭХ, мвт. кВт.ц	ЭХ, %	ЭХ зардал, сая тогтрог			2024			2025			2026								
								I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV			
А. Хэмжүүр, тоонооны чиглэлээр хэрэгжүүлэх ажлууд																						
1	Гэрээг шинэчлэх, алданги гэгдэх, хэмнэлтгэж зөв огоох	0																				
2	Уурын хэлтээнд шардлагатай хэмжүүр, тохируулагч хаалт суурилуулах	29.1																				
	Дүн	29.1																				
Б. Уур, халаагчийн зардалыг бууруулах чиглэлээр хийгдэх ажлууд																						
3	Уур, дулааны гална дотор шугам тэдгээрийн хаалтуудыг дулааглах	5.5	1.21	10.00	29.25	0.19	0.38															
4	Бариалын ханших хийгдэх дулааглах, засварлах, шинэчлэх	40	2.4	20.0	58.5	0.7	0.76															
5	Уурын шугаманд тэргүүд суурилуулах	4.5																				
6	Ачаа оруулах хаалгаанд хониг хийх	0.5	0.1	1.0	2.9	0.2	0.04															
7	Агаарын хатаагчийн технологийг сайжруулах	10	0.5	4.0	11.7	0.9	0.15															
8	Халаагчийн системд тепломонтажтор суурилуулах	50	1.0	8.0	23.4	2.1	0.30															
	Дүн	110.5	2.8	23.0	67.3	0.7	0.87															
В. Менежментийг сайжруулах чиглэлээр хийгдэх ажлууд																						
10	Бусад ажлууд	0.2																				
	Дүн	0.2	0.0	0	0	-	0.00															
	НИЙТ ДҮН	139.8	2.8	23.0	67.3	0.7	0.87															

Боловсруулсан: Нэхий таннери ХХК-ийн ЭХХМ / П. Дашдаваа

Зураг 2-6. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төлөвлөгөө

2.1.1.2 Усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
1	Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын үнд ахуйд болон мод усалгаанд гүний ус ашигласнаар усны нөөц багасна	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгаа хийж байх, мэдээллийн хуудсыг зохих газруудад байрлуулж шинэчилж байх	Үйлдвэрийн байр
		Усны нөөцийн хомсдолоос сэргийлэхийн тулд эх үүсвэр дээр тоолуурыг заасан хугацаанд баталгаажуулж байх, төлбөрийн тогтмол төлөх	Үйлдвэрийн байр
	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа алдагдах холбогдох стандартад нийцэхгүй байх /MNS 6561 : 2015/	Үйлдвэрийн Цэвэрлэх байгууламжийн технологийн сайжруулалт хийх	Үйлдвэрийн цэвэрлэх байгууламж

Үйлдвэрийн технологид ашиглах ус процессын дагуу 3 удаа эргүүлэн ашиглалт хийгдэж байна. Энэ нь удаа ашиглах цэвэр усны хэрэглээг багасгадаг. Харин ажилчдын ахуйд ашиглах усны хэрэглээг зөв зохистой хэмжээнд байлгах зорилгоор усны цорго, 00 өрөөнүүдэд зөвлөмж, анхааруулах санамж тэмдгүүдийг шинэчилж байршууллаа.



Зураг 2-7. Санамж тэмдэглэгээнүүд

Мөн үйлдвэрийн сантехникийн шугам хоолой зэрэгт ус алдаж байгаа, гэмтэл гарсан эсэхийг цэвэрлэгээний ажилчид шалгаж хэрэв эвдрэх, гэмтэл гарсан тохиолдолд засварлуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Үйлдвэрийн ус ашиглалттай хэсэг бүрд усны тоолууржилт хийгдсэн байдаг. Ус тоолуур бүрийн баталгаажуулалтын гэрчилгээ, лац тус бүрийг шалгалт, бүртгэлийг хийсэн. 2024 оны байдлаар баталжуулалтын хугацаа дууссан тоолуур бүртгэгдээгүй байна. Мөн усны төлбөрийг тоолуурын заалтын дагуу сар бүр төлбөрийг тогтмол төлдөг. 2024 оны 10-р сар хүртэл нийт 373.6 сая төгрөгийн төлбөрийг төлсөн.

Хүснэгт 2-4. Усны тоолуурын бүртгэл

Загвар	Голч, мм	Дугаар	Дуусах хугацаа
LX26	50	2209099969	2025.01.05
LXLC	50	202303846	2026.04.25
LXSGR	40	202302345	2025.12.06
LXSG	25	202301551	2026.04.30
LXSG	20	202300981	2026.04.30
LXSG	32	202301952	2026.04.30

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР **МАСМ**

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ120148.....

.....-Д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXSGR загварын 16 м³/ц м³/ц
хэмжих хязгаартай 40 мм-ийн голчтой № 202302345 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 018 лацаар битүүмжилж
(доогуур зурах)

..... 2025 оны 12 -р сарын 06 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 00000 м³

Лабораторийн тэмдэг
03

Улсын шалгагчдын гарын үсэг, тэмдэг
2023 оны 12 -р сарын 06 -ны өдөр

Зураг 2-8. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ №029662

Цэвэрлэх байгууламжийн шинжилгээний үр дүнгүүдээс үүдэн технологийн сайжруулах судалгаа хийх, төсөв өртгийн үнийн судалгааг хийх ажлыг зохион байгуулж ажиллаа. Үүний хүрээнд ус ашиглалт, үйлдвэрлэлээс гарах бохир усны хэмжээ болон механик бохирдлын хэмжээг бууруулах боломжтой технологийн засварыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үйлдвэрээс ирэх бохир усан дахь үс, ноос, лаг, хог болох умбуур хаягдлыг авах зориулалттай механик цэвэрлэгээг шинэчлэх ажил хийгдсэн. Энэ ажлын хүрээнд эргэх түлхийг шинэчилж, голыг шинээр зорж, эргэх хурдыг нь багасгаж өгсөн.



Зураг 2-9. Механик цэвэрлэгээний түлх, голыг шинэчилсэн

2. Үйлдвэрлэлийн технологийн явцад ашиглах усны хэрэглээ болон химийн бодисын ашиглалтын хэмжээг бууруулах зорилгоор ширний дэвтээлгэ, шохойдлогын барбанаас гарах усыг цэвэрлэх байгууламж руу явахаас өмнө хөвж байгаа зүйлсийг дахин эргэлдүүлж, ашигласан шингэнээс үсийг салгах зориулалттай үс шүүлтүүр төхөөрөмж суурилуулсан. Үүнээс гадна хэрэглэсэн шингэнд ууссан үс байгаа нь шохойжуулагч шингэнийг дараагийн багцуудад дахин ашиглах боломжийг хязгаарладаг. Ингэснээр гол үүсэх үр дүн нь:
- Органик бохирдлын хэмжээ, түүний дотор азотын ачаалал мэдэгдэхүйц буурах; ялгарсан нийт азотын дөрөвний нэг нь шохойжилт, үс салгаснаас үүдэлтэй.
 - Дахин ашиглах эсвэл зайлуулахад тохирох мэдэгдэхүйц бага хэмжээний лаг гарах.
 - Бохир үс цэвэрлэх зардал бага (химийн бодис, эрчим хүч гэх мэт).



Зураг 2-10. Нойтон, дэвтээлгэний барабан

Цэвэрлэх байгууламж руу явахаас өмнө эргэлдүүлж, ашигласан шингэнээс үсийг салгах зориулалттай үс шүүлтүүр төхөөрөмж юм. Үсийг муудаж дордохыг багасгахын тулд үсийг салгах ажлыг үс сулрахтай зэрэгцүүлэн хийх нь технологийн хувьд үр дүнтэй. Үсийг салгасны дараа ашигласан шингэнийг эслэг хуваахад дахин ашигладаг. Арьс ширний чанарт нөлөөлөхгүйгээр 15-20 хүртэл удаа үргэлжлүүлж эргэлдүүлж болно. Дахин боловсруулах систем нь үсийг салгах/эслэг хуваахад шаардагдах их усны хэрэглээг бууруулахад тусалдаг.

3. Цэвэрлэх байгууламжид агааржуулах бассейн дээр хөөс хадгалах зорилготой бороожуулалтын ажлыг 2024 оны 10-р сарын 07-ноос 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Гол хийгдсэн ажлуудад:
 - Ф25,20,15 PVC шугамаар ерөнхий усны тэжээл татсан
 - 22 ш босоо шугам Ф15 шугамаар босоо шугам татсан
 - Босоо шугамын үзүүр боож шүрших гуулин хошууг угсарсан
 - Хураах бассейнд 1.5 квт чадалтай 55м напортой 220 в шүүр насос байрлуулж тунаасан усаар бороожуулалтыг хийсэн
 - Ф25 Хог шүүгчийг шугамд байрлуулсан
 - Шүрших 22 ш хошуу дээр шүүртэй иймд бөглөрөх магадлал бага хог шүүгч болон хошуу зэрэг бөглөрвөл цэвэрлэх бүрэн боломжтой.



Зураг 2-11. Бороожуулалт суурилуулсан байдал

2.1.1.3 Хөрсөн орчин үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
1	Түүхий эд материал тээвэрлэн ирэх тээврийн хэрэгсэл олон	Тээврийн хэрэгсэл нэвтрэх зөвшөөрөл болон зааварчилгааг өгч тогтсон маршрутын	Замууд

	салаа зам үүсгэснээр хөрсний эвдрэлд нэмэгдэх	дагуу тээвэрлэлт хийлгэх. Зориулалтын талбайд тээврийн хэрэгслийг байршуулах	
2	Түүхий эд материалыг зориулалтын бус талбайд буулгаснаар хөрс бохирдох	Түүхий эд /арьс, шир гэх мэт/ буулгах зориулалтын талбайг бэлтгэх	Түүхий эд буулгах талбай
3	Химийн бодисын зохисгүй хэрэглээнээс хөрс бохирдох	Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийг чандлан баримтлах, ХАЛМ-ын дагуу хадгалж ашиглах, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Үйлдвэрийн химийн бодис хадгалах агуулах
4	Шатах тослох, материал, нефтийн бүтээгдэхүүн асгарч хөрсөн бүрхэвч бохирдох	Тээврийн хэрэгсэл зогсох талбайд санамж тэмдэг байршуулах	Үйлдвэрийн талбай

Үйлдвэрийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгслийн жолоочид хамгаалалтын алба болон ХАБ-н ажилтан зааварчилгаа өгч ачаа, материал, түүхий эдийн зориулалтын талбай бүрт буулгаж ажиллаж байна. Мөн ажилчдын тээврийн хэрэгсэл үйлдвэрийн гадна талд зориулалтын хатуу хучилттай зогсоолд байршуулдаг. Химийн бодисын хадгалах агуулах нь холбогдох стандарт нийцсэн бөгөөд химийн бодис ачих, буулгах талбай нь бүрэн хатуу хучилттай байна. Иймд олон салаа зам үүсэх, хөрсний эвдрэл, бохирдол үүсэх нөлөөлөл бага юм.


Агуулахад бодис, материал ашиглагдаж явцад асгарсан тохиолдолд ашиглах боломжтой тасалгаа бүрд шингээгч материалуудыг байршуулж өглөө.

Химийн бодисын агуулахад стандартын дагуу тэмдэг тэмдэгжүүлэлтийг бүрэн байршуулсан.



Зураг 2-12. Химийн бодисын агуулахын тэмдэгжүүлэлт

Мөн авто машин зогсох талбайд шатах тослох, материал, нефтийн бүтээгдэхүүн асгаруулахаас сэргийлж санамж тэмдгийг байршуулсан.



Зураг 2-13. Тэмдэгжүүлэлт

2.1.1.4 Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
1	Ажилчдын хатуу шингэн хог хаягдлын улмаас хөрс бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, Дархан-Уул аймгийн Дархан сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зайлуулж байх. Хог хаягдлыг шатааж устгахыг хатуу хориглох.	Үйлдвэрийн талбай орчмын хөрс
		Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх, самбар пайз байрлуулах	
2	Хог хаягдлыг ил задгай хаясны улмаас хөрс, ургамал бохирдох үүнийг мал амьтан идэж хордох	Ажиллагсдад анхааруулга санамж өгч байх, үйлдвэрийн барилга, хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	Ногоон байгууламжийн талбай

2024 оны 09- р сард Хот тохижилт үйлчилгээний газартай Хог тээврийн гэрээг сунгаж шинэчилсэн. Үйлдвэрээс үүсэх хог хаягдлыг зориулалтын талбайд болон саванд хаяж тээвэрлэлт, тогтмол хийж гүйцэтгэсэн. 2024 оны байдлаар сар бүр тогтмол 5-7 удаагийн ачилт тээвэрлэлтийг хийж гүйцэтгэсэн. Хог хаягдлын хэсэгт дэлгэрэнгүй тусгалаа.

Аймгийн мал эмнэлгийн газартай гэрээ байгуулж үйлдвэрийн барилгад нян бактер, халдваргүйжүүлэх зориулалттай бодисоор ариутгалыг хийж гүйцэтгэсэн.

МАЛ ЭМНЭЛГИЙН ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙСЭН АКТ № 23
2024 он 11 сар 15 өдөр

1. Мал эмнэлгийн халдваргүйтгэл хийсэн газрын мэдээлэл:

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: <u>Мал эмнэлгийн газар</u>	Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ үзүүлэх баталгааны тэмдгийн (код) индекс:
Улсын бүртгэлийн гэрчилгээний регистрийн дугаар: <u>427.9867</u>	
Хаяг, байршил: <u>Дархан сум, Д-р.д.а.т.</u>	
Халдваргүйтгэл хийсэн ажилтны овог, нэр, албан тушаал: <u>Б.Рэнхзориг, У.Монголор</u>	
Утас, и-мэйл: <u>99385240, 86600030</u>	

2. Халдваргүйтгэл хийгдсэн газрын мэдээлэл:

Иргэн, хуулийн этгээдийн нэр: <u>Дархан сум 13-р.д.а.т. Үндэсний н. район</u>	
Хаяг, байршил: <u>Дархан сум 13-р.д.а.т. Үндэсний н. район</u>	
Улсын бүртгэлийн гэрчилгээ/Регистрийн дугаар: <u>4270288</u>	
Хариуцсан эрх бүхий удирдах албан тушаалтан: <u>ХАБГА-ын ажлын</u>	Албан тушаал: <u>ХАБГА-ын ажлын</u>
Овог, нэр: <u>Б.Рэнхзориг</u>	Утас, и-мэйл: <u>8889496</u>
Үйл ажиллагааны чиглэл: <u>арьс шир боловсруулах үйлдвэр</u>	

3. Халдваргүйтгэлийн мэдээлэл:

Халдваргүйтгэл:	Эхэлсэн хугацаа: <u>2024 он 11 сар 15 өдөр, 15 цаг 40 мин;</u>
	Дууссан хугацаа: <u>2024 он 11 сар 15 өдөр, 17 цаг 37 мин;</u>
Халдварагүйтгэл хийх зорилго, шаардлага: (✓-тэмдэглэх)	
• Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл: <input checked="" type="checkbox"/>	
• Зориудын буюу зайлшгүй халдваргүйтгэл: <input type="checkbox"/>	
Бүртгэгдсэн, голомт үүссэн өвчний нэр: (.....)	
○ Явцын халдваргүйтгэл: <input type="checkbox"/>	
○ Төгсгөлийн халдваргүйтгэл: <input type="checkbox"/>	
Халдваргүйтгэл хийсэн: (Хэрэглэсэн аргаас шалтгаалан м ² /м ³ аль тохирох доогуур зурах)	
• Барилга, байгууламж	тоо хэмжээ, м ² /м ³
• Мальн хашаа, хороо, байр	тоо хэмжээ, м ² /м ³
• Бэлчээр, талбай/гадна орчны/	тоо хэмжээ, м ² /м ³
• Худалдаа, үйлчилгээний талбай	тоо хэмжээ, м ² /м ³
• Тэжээл, тэжээлийн агуулах	тоо хэмжээ, м ² /м ³
• Мальн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний агуулах, зоорь	<u>2</u> тоо хэмжээ, <u>2000 м²</u> м ² /м ³
• Уст цэг, худаг	тоо хэмжээ, м ² /м ³
• Тонго төхөөрөмж, хэрэгсэл	тоо хэмжээ, м ² /м ³
• Тээврийн хэрэгсэл (онгоц, автомашин, вагон, чингэлз)	тоо, м ² /м ³
• Бууц, санвас, хөлдөвч	тоо хэмжээ, м ² /м ³
• Мал, амьтны хүүр, сэг зэм	тоо хэмжээ, м ² /м ³
• Бусад	тоо хэмжээ, м ² /м ³
Халдваргүйтгэлд:	
Ашигласан бодисын нэр: (..... <u>Нолонд 10кг</u>))	
Бэлтгэсэн уусмалын концентраци: (..... <u>1:1000</u>))	
Хэрэглэсэн уусмалын хэмжээ: (..... <u>10л</u> (<u>10000 л</u>)))	
Тухайн орчны нөхцөл: Байр, орчны температур (..... <u>13c</u>))	
Халдваргүйтгэл хийсэн арга: (✓-тэмдэглэх)	
• Шүрших <input checked="" type="checkbox"/>	
• Мананцаржуулах <input type="checkbox"/>	
• Нян устгах үйлчилгээтэй хөөс ашиглах <input type="checkbox"/>	
• Цахилгаан идэвхт хлоридын уусмал ашиглах <input type="checkbox"/>	
• Хий ашиглах <input type="checkbox"/>	

зөвлөмж: Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийж, халдваргүйтгэл хийсэн газрын хөлдөвч, зоорь, талбай, хашаа, хороо, байр, автомашин, вагон, чингэлз, бууц, санвас, хөлдөвч, түүхий эд, бүтээгдэхүүний агуулах, зоорь, худаг, төхөөрөмж, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний агуулах, зоорь, уст цэг, худаг, мананцаржуулах, нян устгах үйлчилгээтэй хөөс ашиглах, цахилгаан идэвхт хлоридын уусмал ашиглах, хий ашиглах.

ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙСЭН
ТЭМДЭГ
МАЛ ЭМНЭЛГИЙН
ЛАБОРАТОРИ
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР
ХҮЛЭЭН АВСАН:
Б.Рэнхзориг
У.Монголор

Зураг 2-14. Мал эмнэлгийн халдваргүйтгэл хийсэн акт

2.1.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 2-5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Хөрсний үржил шимтэй байдлыг хадгалах, агаарт тоосжилт бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх	Ногоон байгууламжийн талбайг арчилж тордох	Үйлдвэрийн ногоон байгууламжийн талбайд /4,129.75 м2/	м ²	4,129.75	-	2,000,000	6,7,8,9-р саруудад	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тухай хууль Газрын тухай хууль MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт

Үйлдвэрийн талбай дах ногоон байгууламжийг тордох цэвэрлэх ажлыг цэвэрлэгээний ажилчид хариуцаж ажилладаг бөгөөд дулааны улиралд сар бүр тогтмол цэвэрлэгээ хийж ажилласан. Энэ жилд унасан хур тунадасны хэмжээ их байсан тул усалгаажилт шаардлагагүй гэж үзэн хийгээгүй болно.



Зураг 2-15. Ногоон байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ

2.1.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төсөл хэрэгжих талбай орчимд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй болно.

2.1.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2-б. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ
1	2
Аянга цахилгаан	Үйлдвэрт ашиглагдаж байгаа газардуулгын эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлнэ
Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх. Галын булангийн үзлэгийг сар бүр хийх Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх Онц байдлын үед ажиллах гамшгийн төлөвлөгөө гаргуулах
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гэнэтийн болзошгүй байдлаар үйлдвэрт осол аваар гарах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид цахилгааны хүчдэлд цохиулах, түлэгдэх	Үйлдвэрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр тогтмол хангах, бүртгэл хийх ХАБЭА-н дүрэм журмыг таниулах сурталчлах, сургалт өгөх. Үүнд: -Ажил олгогчийн сургалт - Нийт ажилтны сургалт - Химийн материалтай харьцах ажилтны сургалт - Гүүрэн краны оператор мэргэшүүлэх сургалт -Оосорлогч, дохиочны сургалт
Химийн бодисын асгаралт	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах асгаралтын иж бүрдэл байршуулах
Химийн бодисын нөлөөнд өртөх	Химийн ослын үед ажиллах төлөвлөгөө батлуулах Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар агуулахын ажилчдад сургалт зохион байгуулах
Химийн бодисын агуулахын аюулгүй байдал алдагдах	Химийн бодисын агуулахад тогтмол хугацааны давтамжтайгаар хяналт хийж, тэмдэглэл хөтлөх - Химийн бодис сав баглаа боодлын жилийн эцсийн тооллого. - Химийн бодисын агуулахын бүрэн бүтэн байдлыг шалгах, осол, асгарал шалгах - Ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийн бүрэн бүтэн байдал

3 Аянга цахилгаан

Үйлдвэрийн дарга, техникчид, ХАБ-ын ажилчид Үйлдвэрт ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн үзлэгийг хуваарийн дагуу хийж, засвар үйлчилгээг гүйцэтгэсэн.

Мөн Үйлдвэрт ашиглагдаж байгаа газардуулгын эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлж баталгаажууллаа. Үйлдвэрт нийт 37 газарт АНУ-д үйлдвэрлэсэн BST-101 тип багажаар газардуулгын эсэргүүцэл хэмжиж харгалзах стандарт нормтой харьцуулахад бүгд хэвийн эсэргүүцэлтэй байна.

Тоноглолын газардуулгын эсэргүүцэл
хэмжсэн Протокол №

2024.09.05.сар.10өдөр

Объектын нэр: НЭХИЙ ТАННЕРИ ХХК

Хэмжилт хийсэн багажны тип ВСТ-101 № 774


Үйлдвэрлэсэн улс АНУ

Д/д	Тулгуурын төрөл	Хэмжилтийн дүн Газардуулгын эсэргүүцэл (Ом)	Зохих стандарт норм хэмжээ	Дүгнэлт
1.	5-н Эабхар	1.74 Ом	4 Ом	Хэвийн
2.	7-н Эабхар	2.05 Ом	4 Ом	Хэвийн
3.	2-н Эабхар	2.0 Ом	4 Ом	Хэвийн
4.	1 Эабхар өслүүр	1.9 Ом	4 Ом	Хэвийн
5.	10борлогч байгууламч	1.78 Ом	4 Ом	Хэвийн
6.	Байгууламч зин тал	2.3 Ом	10 Ом	Хэвийн
7.	Байгууламч зин	4.5 Ом	10 Ом	Хэвийн
8.	0кв-н ХХБ	2.08 Ом	10 Ом	Хэвийн
9.	0/0кв 630кВА -1	2.08 Ом	10 Ом	Хэвийн
10.	6/0,4кв трансформатор-2	3.44 Ом	4 Ом	Хэвийн
11.	6/0,4кв трансформатор-3	3.01 Ом	4 Ом	Хэвийн
12.	6/0,4кв трансформатор-4	2.75 Ом	4 Ом	Хэвийн
13.	Насажуу урс	3.7 Ом	4 Ом	Хэвийн
14.	0,4кв-н ХХБ -1	2.7 Ом	4 Ом	Хэвийн
15.	0,4кв-н ХХБ	1.95 Ом	4 Ом	Хэвийн
16.	Аялгын бүлэг	9.5 Ом	10 Ом	Хэвийн
17.	Аялгын бүлэг	9.05 Ом	10 Ом	Хэвийн
18.	Аялгын бүлэг	7.74 Ом	10 Ом	Хэвийн
19.	Аялгын бүлэг	7.89 Ом	10 Ом	Хэвийн
20.	Аялгын бүлэг	9 Ом	10 Ом	Хэвийн
21.	Аялгын бүлэг	9.75 Ом	10 Ом	Хэвийн
22.	Аялгын бүлэг	10 Ом	10 Ом	Хэвийн
23.	Аялгын бүлэг	8.4 Ом	10 Ом	Хэвийн
24.	Цахилгаан цэвэр	2.4 Ом	4 Ом	Хэвийн
25.	Цайтга гажуурга цэвэр	3.1 Ом	4 Ом	Хэвийн
26.	110-р тасал -1	3.9 Ом	4 Ом	Хэвийн
27.	110-р тасал -2	2.75 Ом	4 Ом	Хэвийн
28.	111-р тасал -1	3.07 Ом	4 Ом	Хэвийн

Туршилтын инженер



2024 онд үйлдвэрийн барилга дах нийт галын хорны цэнэг, галын булангийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хянаж, үзлэгийн хуудаснуудыг бөглөлөө. Үйлдвэрийн ХАБ-н ажилтан шинээр ажилд орсон ажилтан бүрд гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, сургалт орсон.



Зураг 2-17. Галын хорны үзлэгийн хуудас

- Онц байдлын үед ажиллах гамшгийн төлөвлөгөө гаргуулах

Онц байдлын үед ажиллах гамшгийн төлөвлөгөөг үйлдвэрийн ХАБАЭ-ны ажилтан боловсруулж Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан.

**ГУРАВ. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Дархан нэхий” ХК-ийн захирал

Батлав:

Б.Гэрэлмаа

Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хохирол бага даван туулахад чиглэсэн төлөвлөгөө, төсвийг жил бүр батлан холбоо, бүлгийн хэрэгцээг техник хэрэгслийг бүрдүүлэх, шинэчлэх, мэдлэг, дадлага олгох сургалт зохион байгуулахад шаардагдах зүйлсээр хангаж ажиллана.

Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө

**3.1 Химийн хорт бодис, цацраг туяа алдагдах аюулаас урьдчилан сэргийлэхэд зохион байгуулах ажлын төлөвлөгөө
2024/11/10**

№	Авах арга хэмжээ	Хугацаа	Үнэ	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн
1	Химийн материал, бодис хадгалж буй агуулахын үйл ажиллагааг стандартын дагуу явуулах	2023-2025 он	2020 он -1 077 000 төг 2021 он - 800 000 төг 2022 он - 1 000 000 төг	Стандартанд нийцсэн ХМ-н агуулахын үйл ажиллагаа явагдах	Хангамжийн менежер, ХМНА
2	Хэрэглэж буй химийн материал, бодисын ХАЛМ-ийг боловсруулж агуулах, нойтон цэхэд ил тод тавьж байрлуулах	2024-2026 он	150 000төг	Химийн бодис шинээр нэмэгдэх бүрт ХАЛМ боловсруулж ажилтнуудад мэдээлж ил тод байрлуулна.	Хангамжийн менежер, Лаборант
3	Химийн материал, бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад мэдлэг олгох сургалт хийх	Жил бүр	2023 он -250000 төг 2024 он - 250000төг 2025 он - 250 000 төг	Химийн материалтай харьцаж ажилладаг ажилтнуудын мэдлэг, анхаарал болгоомж, АА-г хангаж ажиллана.	ХАБЭА, Эрүүл ахуйч, Хангамжийн менежер
4	Химийн материалын сав, хаягдлыг хуулийн хугацаанд хадгалах, устгалд оруулах	Жил бүр	2023 он - 200000 төг 2024 он - 200000 төг 2025 он - 200000 төг	Химийн бодистой сав, хог хаягдлын хүн мал амьтдад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.	Хангамжийн менежер, ХАБЭА-н ажилтан

3 ХАБЭА

2024 оны 02-р сарын 27 оны өдөр А/04 дугаартай “Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл олголт, ашиглалтын журам” болон “Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл олголт, ашиглалт, олголтын норм”-ыг гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэн баталсан.

НЭХИЙ ТАННЕРИ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/04

Дархан-Уул аймаг

Журам шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 120 дугаар зүйл, 121 дүгээр зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний хорооны 2021 оны 6-р сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. Тус компанийн үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах, түүнээс хамгаалах зорилгоор “Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл олголт, ашиглалтын журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Ажлын хувцас хамгаалах хэрэгсэлийн ашиглалт, олголтын нормыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан /У.Аззаяа/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны 6-р сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай” А/13 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БЯМБАЦОГТ

Нэхий таннери ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 02 сарын 27-ны өдрийн
АХЖТ тоот тушаалын хавсралт
ХХК



НЭХИЙ ТАННЕРИ ХХК-НИЙН АЖЛЫН ХУВЦАС, ХУВИЙН

ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Нэхий таннери ХХК-д ажиллаж байгаа нийт ажилтануудын ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах болон бүртгэх, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Тус компаний нийт ажилчид ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу тогтмол өмсөж хэвшүүлэх, ажилтны ХАБЭА-г хангуулах зорилготой.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 2.1. НЭХИЙ ТАННЕРИ ХХК нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйл, Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 120,121 дүгээр зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний хорооны 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 01 дугаар тогтоолыг үндэслэн нийт ажилтнуудад ажлын хувцас хамгаалах хэрэгсэл олгоно.

ГУРАВ. АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛИЙН НЭР ТОМЬЁО.

ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1 “Тусгай хувцас” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай. Бээлий зэрэг хэрэгслийг
- 3.2 “Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг
- 3.3 “Хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрийн нөхцөл, бусад хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зориулалт бүхий стандартад нийцсэн байна.
 - Нүд хамгаалах хэрэгсэл
 - Хөл хамгаалах хэрэгсэл
 - Гар хамгаалах хэрэгсэл
 - Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл

ДӨРӨВ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Ажилтан бүрийн хамгаалах хэрэгсэл нь тухайн ажлыг гүйцэтгэхэд зохицсон эсэхийг ажилтан болон удирдлага /менежер/ дараах шаардлагаар магадлана.
- 4.2. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгсэл нь ажлыг гүйцэтгэхэд саад болхооргүй байхаас гадна эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байна.
- 4.3. Ажлын хувцас нь хүний бие хүрэлцэх хэсгүүдэд цочроо, шархлаа үүсгэхгүй, ширүүн хурц эрмэггүй байх
- 4.4. Компаний ажилчдын хувцас нь батлагдсан онго загвар иж бүрдэл ажлын байр, ажиллах нөхцөлд бүрэн нийцсэн байна.
- 4.5. Загвар нь ажлын болон хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц эсвэл хэмжээний сонголттой байх.
- 4.6. Хамгаалах хувцасны стандарт хангасан, эдийн засгийн хувьд үр ашигтай байх.

ТАВ. КОМПАНИЙ ҮҮРЭГ

- 5.1 НЭХИЙ ТАННЕРИ ХХК нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйл, Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 120,121 дүгээр зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний хорооны 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 01 дугаар тогтоолыг баримтална.
- 5.2 Компани нь ажилчдад ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажилтнуудын аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Нэхий таннери ХХК-ийн орон тооны бус ХАБЭА-н зөвлөлийн анхны хуралдаанаар Нэхий боловсруулах үйлдвэр, Дархан таннери салбарын Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн нормтой танилцаж зөвшөөрсөн бүртгэл

№	Албан тушаал	Овог нэр	Нэхий боловсруулах үйлдвэрийн ажлын хувцас, ХХХ-ийн норм		Дархан таннери салбарын ажлын хувцас, ХХХ-ийн норм	
			Зөвшөөрсөн	Зөвшөөрөхгүй	Зөвшөөрсөн	Зөвшөөрөхгүй
1	ХАБЭА-н зөвлөлийн дарга	У.Аззаяа				
2	Гүйцэтгэх захирал	Бямбацогт				
3	Түүхий эд бэлтгэлийн албаны захирал	Я.Аззаяа				
4	Эрүүл ахуйч, эмч	Д.Оюунчимэг				
5	Бүртгэл тооцооны ажилтан	Т.Отгонтуяа				
6	Аж үйлдвэрийн инженер	П.Дашдаваа				
7	Технологич, багийн ахлагч	Ц.Энхжаргал				
8	Технологич, багийн ахлагч	Б.Цолмон				
9	Шахмал ширний үйлдвэрийн менежер	Б.Өөлд				
10	Ажилтан /нэхий/					
11	Ажилтан /шир/					


Танилцаж зөвшөөрсөн:

Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн дарга

Э.Батсайхан

Зураг 2-18. Журам, норм баталсан тушаал

Байгууллагын шинэчлэн баталсан журмын дагуу үйлдвэрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр тогтмол хангах, бүртгэл хийх ажлыг тогтмол гүйцэтгэсэн.



рхан таннери шир, саван боловсруулах үйлдвэрийн "Хувийн хамгаалах хэрэгсэл" олгосон баримт 2024.....

Дла	Нэр	Тасаг	Албан тушаал	Сар өдөр	хамгаалах хэрэгсэл			Гарын үсэг
					Алгатай бээний	Ризин бээний	Хошуувч	
1	Тасгийн дарга	161	Д.Аюуш	1/11	1	1	1	Д.Аюуш
2	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/11	1	1	1	Д.Аюуш
3	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
4	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
5	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
6	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
7	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
8	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
9	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
10	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
11	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
12	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
13	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
14	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
15	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
16	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
17	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
18	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
19	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
20	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
21	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
22	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
23	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
24	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш
25	Тасгийн дарга	181	Д.Аюуш	1/12	1	1	1	Д.Аюуш

Зураг 2-19. Хувийн хамгаалах хэрэгсэл олгосон бүртгэл

Үйлдвэрийн ХАБ хариуцсан мэргэжилтэн үйлдвэрлэлтийн явцад нийт ажилчдадаа өдөр тутмын зааварчилгаа, хуваарь шалгалт зэргийг тогтмол хийж ажиллаж байсан. ХАБЭА-н сургалтыг Ойгон нөмрөг ТББ-тай 2024 оны 06-р сард байгууллагын нийт ажилчдад ХАБЭА-н мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах, зөвлөгөө өгч, сургалтын ач холбогдлыг таниулах гэрээ байгуулж ажилласан.

ХАБЭА-н дүрэм журмыг таниулах сурталчлах, сургалт өгөх. Үүнд:

- Ажил олгогчийн сургалт
- Нийт ажилтны сургалт
- Химийн материалтай харьцах ажилтны сургалт
- Гүүрэн краны оператор мэргэшүүлэх сургалт
- Оосорлогч, дохиочны сургалт



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2024 он 04 сарын 20 өдөр

№ _____

Дархан-Уул аймаг

Энэхүү гэрээг нэг талаас “НЭХИЙ ТАННЕРИ” ХХК /цаашид “Захиалагч” гэх/, РД:4280288 түүнийг төлөөлж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал ажилтан У.Азаяа, нөгөө талаас “ОЙГОН НӨМРӨГ” ТББ /цаашид “Гүйцэтгэгч” гэх/, РД:8271275 түүнийг төлөөлж Сургалтын менежер М.Төмөрхуяг нар нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр сургалт захиалагч байгууллагын нийт ажилтанд ХАБЭА-н мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах, Зөвлөгөө мэдээлэл өгөх болон харилцан ашигтай хамтран ажиллахтай холбогдсон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Гүйцэтгэгч тал нь Хөдөлмөрийн, Нийгмийн хамгааллын Сайдны 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/173 тоот тушаалаар батлагдсан журмыг үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, гэрээний хугацаанд захиалагч талийн нийт ажилтан болон ХАБЭА-н ажилтанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.
- 1.3 Захиалагч байгууллагын ХАБЭА-н ажилтан болон Сургалтын мэргэжилтэн нь нийт ажилтнуудад сургалтын тухай бүрэн ойлголт өгч сургалтын ач холбогдлыг таниулан сургалтын байгууллагатай хамтарч ажиллана.
- 1.4 Захиалагч тал нь сургалт зохион байгуулах зөвлөн туслах явцад Гүйцэтгэгчийн багш ажилтныг ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ.
- 1.5 Гүйцэтгэгч байгууллага нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”-ын 4.1, 4.2-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд нотлох баримт бичиг нь гэрээний салшгүй нэг хэсэг байж, гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг байна.
